

БҮС НУТГИЙН ХИЛИЙН СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, АРГАЧЛАЛ

Б.Цэдэндамба

ДХИС-ийн Удирдлагын академийн 8012 дугаар дамжааны суралцагч, магистрант, хошууч

Товч агуулга: “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг найдвартай хангах¹” бүс нутгийн хилийн стратегийн хөгжлийн талаар тодорхой мэдлэгтэй байхыг судлаачдаас өнөөгийн цаг үе, нөхцөл байдал зүй ёсоор шаардаж байгааг ойлгуулахыг зорилоо.

Abstract: We aim to make researchers understand that the current times and conditions legitimately require researchers to have a clear knowledge of the development of the regional border strategy to "implement the policy of ensuring the national security of Mongolia and ensure the inviolability of the national border and the security of the territory around the border".

Түлхүүр үг: Монгол улс, төрийн бодлого, бүс нутаг, хил хамгаалалтын стратеги, үйл ажиллагаа.

Keywords: Mongolia, state policy, Region, border protection strategies and activities.

Оршил

Монгол Улсын хил бол олон улсын хилийн нэгээхэн хэсэг юм. Улсын хилийг НҮБ-ийн дүрмээр журамласан шаардлага, зарчимд нийцүүлэн шийдвэрлэж бүтээлчээр ажил хэрэг болгох нь даян дэлхий, бүс нутаг, айл хөрш улсуудын түвшинд энх тайвныг бэхжүүлж, хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Улсын хилийг өөрийнх нь жам ёсны дагуу хууль, зүй тогтолд нийцүүлэн баталгаажуулж, хамгаалж чадваас зөвхөн өөрийн төрөлх эх орон төдийгүй, хөршлөх улсуудад улсын тусгаар тогтнол бэхжиж, ард түмэн нь өөрт заяагдсан эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эзэмшиж, жаргалтай, сайн сайхан амьдрах таатай нөхцөл бүрдсэн гайхамшигтай хүчин зүйл болдог. Эс чадвал иргэд уй гашуу,

зовлон зүдгүүрт автаж, улс орон уруудан доройтож, эцсийн эцэст тусгаар тогтнох статус-квог алдах, аюул занал нүүрлэсэн нөхцөл байдал үүсэх сөрөг үр дагавар дагуулсан субъектив хүчин зүйл болж хувирдаг. Энэ бүхэн олон улсын болон Монгол улсын түүхэнд объектив болон субъектив шинжтэйгээр илэрч тогтоогдсон бодит үзэгдэл, сургамж.

Байгаль, нийгмийн үзэгдэл, шинж байдал хослон хэрэгждэг улсын хил, хязгаарын орон зай дахь тулгамдсан асуудлыг субъектив буюу бодит бус хүчин зүйлээс ангид байлгаж, объектив бодит байдлаар шийдвэрлэж, хэрэгжүүлж болох дардан зам бий. Энэ бол шинжлэх ухаан, тэр дотроос улсын хилийн тухай шинжлэх ухаан, хураангуйлсан байдлаар

¹ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2009 оны 156 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

илэрхийлбэл хилийн шинжлэх ухаан яах аргагүй мөн.

Улсын хилийн тухай шинжлэх ухаан байгааг даян дэлхийн энэ чиглэлийн мэргэжил бүхий эрдэмтэд хөдлөшгүй баримт нотолгоонд тулгуурлан нээн тогтоожээ. Түүнийг XX, XXI зууны зааг дээр НҮБ-ийн дүрмийн хүрээнд байгуулагдсан олон улсын оюуны шинэ бүтээлийг эрхэмлэдэг дээд байгууллага албан ёсоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн EIW0001175 дугаар бүхий гэрчилгээгээр баталгаажуулжээ.

Нэг: Бүс нутгийн хилийн стратегийн төлөвлөлт

Бүс нутгийн хилийн стратегийг төлөвлөхөд анхаарах асуудал

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал халдашгүй дархан байна”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын Үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” Монгол Улсын хилийн тухай хуульд “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна”, Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогод “хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ”, “хил

орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно” гэж тус тус заасан байна. Монгол улс төрийн бодлого нэгдмэл байхаас гадна салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлдэг.

Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.

1. Төрөөс баримтлах бодлого;
2. Бүсчилсэн хөгжлийн бодлого;
3. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.

Энэ нь манай улсын бүх шатны субъектууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдээс, удирдлага болгон мөрдөх онцгой хамааралтай удирдамж болж байна. Энэ эрх зүйн баримт бичгийн бодлогын үндсэн чиглэлд “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах”, “улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” шаардлагатай байгааг харуулж байна.

Бүс нутаг гэдэг нь дэлхий нийтийн нийтлэг ойлголт юм. Эрдэмтдийн үзэж байгаагаар нутаг дэвсгэр, хүн ам, түүхийн нэгдмэл онцлог, байгаль, газар зүйн нөхцөл

байдал түүнчлэн нийгэм, эдийн засаг, цэрэг, соёл боловсрол, хүн ам зүйн онцлог, улс орон бүхний хил хязгаарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого, үйл ажиллагааны зорилго, хэлбэр, агуулга ойролцоо байдал зэрэг олон шалгуур үзүүлэлтийг багтаасан.

Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөрт ой тайгын, тал хээрийн, говь цөлийн, уулын, төвийн гэсэн бүс гэж эрх зүйн хувьд томьёолон цаашид хөгжүүлэх бодлого барин ажиллаж байна. Монгол улсын олон зууны түүхэнд ч тийм онцлог байсан. Тухайлбал, улсын нутаг дэвсгэр нийгмийн байдлыг багцлан үндсэнд нь гурав хувааж дорно чиглэлийн бүсийг Сэцэн хан аймаг, төвийн бүсийг Түшээт хан аймаг, баруун бүсийг Засагт хан (Сайн ноён хожим нэмэгдсэн Ш.А.) аймаг гэж ангилан авч үзэж байлаа.

Монгол Улсын 14 аймаг нь улсын хилийн аймаг учраас газар нутгийн гүний хэмжээ нь аймгийн нутаг дэвсгэрийн орон зайтай давхцаж байдаг. Монгол улсын төрийн хилийн бодлогын стратеги нь хил орчмын аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төдийгүй хэд хэдэн аймгийг багтаасан орон зайд бэлтгэгдэж явагддаг учраас бүс нутгийн хилийн стратегийн хэлбэр шинжийг хадгалдаг байна.

Энэ нь мөн л Монголын олон зууны өвөрмөц түүхэн жишээ, баримтаар нотлогддог. Тухайлбал Сэцэн хан, Түшээт хан, Засагт хан, Сайн ноён хан аймаг аль нь ч гэсэн умард талдаа Оросын хаант улсын хилтэй, зүүн талдаа Манж буюу Зүрчид улс, өмнө этгээдэд Хятад, өрнө талдаа Зүүн Туркестан улстай хил залгаж байлаа. Тухайн үед хил орчмын бүс нутаг гэдэг ойлголт нь

бүхэлдээ бүс нутгийн хэмжээнд хамаарагдаж, далайц, хүрээ хязгаар, гүн нь өргөн байжээ.

Төрийн хилийн бодлогын бүс нутгийн стратегийн төлөвлөлтийг боловсруулахад зайлшгүй бүс нутгийг үнэлэх шаардлагатай:

Үүнд:

1.Хил орчмын бүс нутгийн шинж байдал

2.Хил орчмын бүс нутгийн ерөнхий шинж

3.Геоулс төр, геостратегийн байдлын тухай

4.Бүс нутаг дахь улс төрийн хүчин зүйл

5.Бүс нутгийн эдийн засгийн байдлын тухай

6.Хилийн бүс нутаг дахь эрх зүй, хэм хэмжээ

7.Хилийн бүс нутагт байгаа төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэгч субъектүүд

8.Хил орчмын цэрэг-улс төрийн нөхцөл байдал

9.Олон улсын харилцаа, нийгэм, хүн ам зүй, шашин шүтлэг, цагаачлалын байдал:

10.Бүс нутгийн кримнологийн нөхцөл байдал

11.Хилийн бүс нутгийн соёлын байдлын тухай

12.Бүс нутгийн физик, газар зүй

Бүс нутгийн хилийн бодлогын стратегийг хэрэгжүүлэгч дараах субъектүүд байна. Үүнд:

- Улсын хэмжээний төрийн байгууллагууд /УИХ, Ерөнхийлөгч, засгийн газрын тэргүүн, ҮАБЗ, Батлан хамгаалах зөвлөл, хилийн асуудлыг шийдвэрлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагууд, төрийн яамууд, мөн холбогдох зарим байгууллагууд/;

- Улсын хилтэй холбогдсон бүс нутгийн болон аймаг, сумдын хуулийн ба гүйцэтгэх засаглалын байгууллагууд;

Төрийн хилийн бодлогын бүс нутгийн стратегийн төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэн улсын хил, хязгаарын орон зай дахь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит боломж нь судалгаа шинжилгээ бөгөөд шинжлэх ухаан, түүн дотроос хил судлалын шинжлэх ухаан, хураангуйлсан байдлаар илэрхийлбэл хилийн шинжлэх ухаан яах аргагүй мөн.

Хоёр. Бүс нутгийн хилийн стратегийн төлөвлөлтийн аргачлал

Үндэсний аюулгүй байдал болон Монгол Улсын аюулгүй байдалд учруулж болзошгүй аюулыг ямар ч нөхцөлд аль бүс нутагт ямар аюул нүүрлэж байгааг эцэслэн тогтоож, шийдвэрлэх шаардлагатай бөгөөд дараах дараалалд багтаан тодорхой ажил гүйцэтгэнэ. Үүнд:

-Тухайн бүс нутгийн нөхцөл байдалд урьд заагдсан асуудлуудын дагуу хийгдсэн үнэлгээг үндэслэн өөр хооронд нь харьцуулан авч үзнэ;

-Тухайн бүс нутагт илэрсэн аюулуудын эрс тэс зөрчилдөөнт байдал, үндсэн шалтгаануудыг илрүүлэн гаргах;

-Эсрэг арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн зүйлүүдийг түүвэрлэж анхааралдаа авч эрэмбэлэх;

-Төрийн хилийн бодлогын стратегээр тухайн бүс нутагт албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн гэж тооцогдож заагдсан аюулуудтай өөрийн судалгааны үр дүнг харьцуулан жижиж үзэх;

-Тухайн бүс нутагт илэрсэн буюу илэрч болох аюулуудыг зөв

- Нутгийн өөрөө удирдах байгууллагууд;

- Олон нийтийн болон аж ахуйн байгууллага, иргэд; тодорхойлоод шийдвэрлэх хэрэгтэй болно.

Аюулыг зөв тогтоосны дараа аюулын эсрэг авах арга хэмжээнүүдийг ойрын болон дунд зайнд, мөн хэтэд шийдвэрлэх хөтөлбөрийг боловсруулна. Бүс нутгийн аюул, түүний шинж байдлыг бодитойгоор тодорхойлохын тулд хилийн орон зай дахь үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй үндсэн аюулыг сайн мэдэж авах шаардлагатай. Эдгээр аюулууд нь:

-Улсын хилийн баталгаажилтын эрх зүйн бүрэн төгс шийдвэрлэгдээгүй асуудал;

-Хэт үндсэрхэг үзэл, шашин, шүтлэг, зан үйлийн шинжтэй өдөөн хатгалга, сепаратизмын үзэл гаргах, эдийн засаг хүн амын олноор дээрэнгүйлэх;

-Үндэсний баялагийг хоослох, сэм дамын худалдаа өсөж, газар авах, хэмжээ хязгаараа тэлэх;

-Гадаад руу стратегийн чухал түүхий эд /бараа/-ийг хэмжээ хязгааргүй ихээр гаргах зөөх;

-Хүн амын шашин шүтлэг, зан заншил, сэтгэл зүйд хагаралдаан гарах, ихээхэн хэмжээний цагаачлал бий болох, хүн амын амжиргааны төвшин буурснаас болж цагийн байдал тогтворгүйтэх;

-Олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг мөн терроризмид өртөгдөх;

-Хилийн бүс нутагт зэвсэгт мөргөлдөөн үүсэх;

-Хил орчмын нутаг дэвсгэрт зэвсэгт тэмцлийн зориулалттай зэвсэг хэрэгсэл хуримтлагдан бий болох;

-Хил дамнасан аваар осол, сүйрэл, байгалийн гамшиг гарах гэх мэт;

Аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхойлсны дараа дор дурдсан үйл ажиллагааг дэс дараалалтайгаар гүйцэтгэнэ. Үүнд:

-Тухайн бүс нутагт илрэгдсэн аюулын байдлыг харгалзан ойрын үед, дунд зайнд, урт хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд суурилсан хилийн бүс нутгийн стратегийг томъёолж тодорхойлох;

-Бүс нутгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулуудаас урьдчилан сэргийлэх, бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тоймлон тогтоох;

-Учирч болох аюулыг бүс нутагт арилгасны үр дүнд тэнд бий болох төлөв хандлагыг гаргаж тавина.

Бүс нутгийн хилийн стратегийн зорилго нь зөвхөн тайван цагт төдийгүй, цэрэг улс төр, эдийн засаг, экологи, бусад нөхцөл байдал эрс хурцадсан үед ч үр дүнгээ өгч байх ёстой.

Өөрөөр хэлбэл бүс нутгийн хилийн стратегийн хэрэгжүүлэгч субъектүүдийн хүлээх чиг үүрэг, хариуцлага зөвхөн тайван нөхцөлд төдийгүй, цагийн байдал эрс хурцадсан нөхцөл байдалд үр ашигтай ажиллах нөхцөл бололцоотой байхаар бэлтгэлийг хангаж байх шаардлага гарна. Зорилгыг зөв тодорхойлох явдал стратегийн чухал хэсэг юм.

Учирч болзошгүй аюулын эсрэг авах арга хэмжээг төлөвлөхөд харгалзан үзэх нөлөөллүүд:

-Бүс нутгийн хэмжээний цэрэг улс төрийн болон бусад онцгой нөхцөл байдлын шинж төлөв,

ялангуяа хөрш хоёр улстай харилцаж байгаа харилцааны байдал;

-Хил орчмын бүс нутагт оршин сууж хилийн бодлогыг хэрэгжүүлэгч субъектуудын байрлал, байдал, хангалт, тэдний алба-байлдааны бололцоо, түүнчлэн дээд шатны газруудын даалгавраар тухайн бүсд гүйцэтгэж байгаа төлөвлөгөөт зорилтуудын хэрэгжилтийг мэдэж байх;

-Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэгч болох яам, тусгай газруудын стратегийн хүч хэрэгсэл, түүнчлэн хил орчмын нутагт аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэгч цэргийн бүс байгууллагууд, тэдгээрийн хил хамгаалах үүрэг, гүйцэтгэх бололцоо;

-Бүс нутгийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх гол үүрэг хүлээсэн яам, тусгай газруудын ажиллагааг загварчилсан норм, хэм хэмжээ /зөвлөмж, арга зүй, тайлбар, лавлах, материалууд/-г тогтоосон бичиг баримтуудыг олж ашиглах гэх мэт;

Улс орны аюулгүй байдалд учирч болзошгүй аюулын эсрэг авах арга хэмжээг боловсруулахад ерөнхийдөө аль бүс нутагт байгааг үл харгалзан тодорхой дараалал бүхий ажиллагааг явуулах шаардлага гардаг.

Улс оронд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, арилгах арга хэмжээнд бүс нутагт хилийн бодлогыг хэрэгжүүлэгч олон төрөл, мэргэжлийн субъектууд оролцдог. Тухайлбал тухайн бүс нутагт байгаа хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн нэгтгэл, газар, олон анги салбарууд оролцоно. Үүнээс гадна тухайн бүс нутагт байгаа гаалийн нэгээс хоёр газар, Хууль Зүйн Яамны харьяаны газар, хэлтсүүд, Тагнуулын

хэд хэдэн газар, Батлан хамгаалах яамны хил халхлалтын анги, нэгтгэлүүд, цагаачлал, автотехник, хүн мал эмнэлгийн болон хорио цээрийн байгууллагууд, чөлөөт бүсийн удирдлага зэрэг, олон яам, тусгай газруудын орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, мөн хэд хэдэн аймаг, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, орон нутгийн оршин суугчид оролцоно.

Бүс нутгийн хилийн бодлогыг хэрэгжүүлэгч субъектүүдийн үүргийг хуваарилхад анхаарах хүчин зүйлс:

-Субъектүүдийн зориулалт, бүтэц бүрэлдэхүүн, байрлал, байдал, хангалт, албаны болон байлдааны бололцоо;

-Ахлах дарга тухайлбал яам, байгууллагын даргын төлөвлөгөөнд багтаан хэрэгжүүлж байгаа зорилтууд;

-Субъектүүдийн ашиглагдаагүй байгаа нөөц, бололцоо, тэдгээрийг учирч болзошгүй аюулаас сэргийлэх, арилгахад ашиглах боломж;

-Тухайн бүс нутагт аюулыг арилгах чиглэлээр субъектүүд тухайлбал яам, тусгай газруудаас стратег, бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэж байгаа зорилтууд;

-Хил орчмын бүсэд учирсан аюулаас сэргийлэх, арилгахад ашиглаж болох орон нутгийн хүч хэрэгслийн нөөц бололцоо.

Төрийн хилийн бодлого урьдчилан төлөвлөгдсөнөөр хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал хангагдаж, гадаад дотоодоос учирч болох аюулаас үндсэндээ сэргийлэгдэн, хамгаалагдах эх үндэс тавигдана. Улсын аюулгүй байдал, үндэсний эрх

ашгийг бүс нутаг, хил орчмын орон зайд найдвартай хангагдах нөхцөл бүрдүүлэхийн тулд хилийн бодлогын бүс нутгийн стратеги нь олон улсын болон бүс нутгийн улс төр, эдийн засаг бусад янз бүрийн нөхцөл байдлыг харгалзан байнга тодотгогдож, боловсронгуй болж байх шаардлагатай.

Дүгнэлт

Сүүлийн гурван жилийн нөхцөл байдлаас дүгнэхэд бүс нутгийн геополитикийн асуудал, дэлхий нийтийг хамарсан цар тахал, бүс нутгийн хэмжээнд үүссэж байгаа цагийн байдал зэрэг нь улсын хилийг манах, хамгаалах асуудалд илүү нухацтай, шинжлэх ухаанч байдлаар хандах, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох, эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх шаардлагатайг харуулсаар байна.

Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх субъектуудад тавигдах хүрээ, тэдгээр зорилтуудыг тодотгох, шаардлага гарвал бүсийн байгууллагуудын нэгдсэн зохион байгуулалтад орох, мөн улсын хилийг манах, хамгаалах асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, эрдэмтэн судлаачдын судалгаа бүтээлд тулгуурлан ялгаж салган Монгол Улсын хэмжээнд хууль тогтоомжоор ажил хэрэг болгон тодотгох шаардлага гарсаар байна.

Монгол улс төрийн бодлого нэгдмэл байхаас гадна салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлдэг учир төрийн хилийн бодлогын стратеги, тэр дундаа бүс нутгийн хилийн стратегийн төлөвлөлт /аргачлал/ нь нэгэн эрх ашигт зангидагдаж, нэгдмэл үзэл бодол, арга билгийг бүрдүүлэхэд чиглэлгдэх учиртай.

Санал

Бүс нутгийн аюулын эсрэг субъектуудын хэрэгжүүлж байгаа арга хэмжээний төрөл, мэргэжлийн онцлог тухайн үеийн нөхцөл байдлыг сайтар тунгааж, субъектуудыг хариуцсан чиг үүрэг зориулалтаар нь ашиглаж, зорилтуудыг нь шинжлэх ухааны үндэстэй бодитой тодорхойлох, тэдгээрийн хоорондын харилцан ажиллагааг нягт сайн зохион байгуулах, хүн, материал, техник, санхүүгийн нөөцийг бүх талаар тасралтгүй хангах асуудлыг шийдвэрлүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ., 2001.
- Монгол Улсын хилийн тухай хууль. УБ., 2016.
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.
- Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002
- Ш.Арвай “Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”. УБ., 2015.